

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2019 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

2019 оны 10 дугаар сарын 04

Багануур дүүрэг

№	Үндэслэл	Хийсэн ажлын биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 17.1.	<p>ЭХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар Паркийн ТЭЗҮ-ийг хэлэлцүүлж цахилгаан хангамжийн техникийн нөхцөл авах ажлын хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. БҮТП-ийн Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт иж бүрэн боловсруулагдаж, НИТХ-н Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлагдсан бөгөөд БХБЯ-ны экспертизүүдийн зөвлөлөөр баталгаажсан. 2. БҮТП-н дэд бүтцийн зураг төслийн ажил нь: Эрчим хүчний хэсгээс бусад нь бүрэн дууссан байна. 3. Байгууллагын дарга Ч.Элбэгсайхан Зураг төслийн цахилгаан хангамжийн асуудлаар Барилга Хот Байгуулалтын Яамны "Захиалагч" ажлын хэсэгтэй уулзалт хийсэн. Тус уулзалтаар дараах нөхцөл байдлыг тодруулсан: <p>БҮТП-д хэрэгжих үйлдвэр, төслүүдэд нийт 65 мВт-ийн эрчим хүчний хэрэглээг шаардагдах бөгөөд өнөөдрийн байдлаар ЭХЯ-д хангамжийн боломж байхгүй тул Диспетчер Үйлчилгээний Төвд Паркийн цахилгаан хэрэглээний горимын тооцоолол хийсний дараа техникийн нөхцөл олгохоор болсон байна.</p>	100%
2	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж	<p>Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын зураг төслийн ажлын хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хот байгуулалт, төлөвлөлтийн газраас гаргасан ажлын даалгаврын зургийн ажлын схемтэй танилцаж, барилга барих талбайн байршлыг газар дээр нь судалсан. 2. Нийслэлийн Засаг даргаар 1067 м.кв газрын захирамжийг гаргуулсан. 3. Хөрөнгө оруулалтын газраар дамжуулан ажлын болон зургийн даалгаврыг Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Худалдан авах ажиллагааны газраас зураг төслийн дэлгэрэнгүй тендер зарлаж хаасан ба 2019.10.04-нд хураангуй тендер зарласан. 2019.10.14-нд тендерийн материалыг нээхээр төлөвлөн ажиллаж байна. 	100%

3	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж	- Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний тендерт Шаннитрэйд ХХК шалгарсан бөгөөд гэрээ байгуулахаар нийслэлийн ЗДТГ-т хүлээгдэж байна.	100%
4	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаал	- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаалаар батлагдсан аргачлал зөвлөмжид нийцүүлэн Захиргааны болон Үйлдвэрлэл, технологийн албаны гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хаагч нарийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэх ажлыг зохион байгуулж байна.	70%
5	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны А/518 дугаар захирамж	Байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэлийг ханган ажиллаж 2019.10.04-ны өдөр Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Х.Ганхтулгаар ахлуулсан ажлын хэсэгт үндсэн 4 чиглэлээр шалгуулж, амжилттай хамгаалсан. Тус шалгалтын бэлтгэл ажлыг хангах үүднээс дараах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд: <ul style="list-style-type: none"> - 2019.09.03-нд нийт албан хаагчид Цагдаагийн Ерөнхий Газрын Сургалтын төвийн жишиг архивтай танилцаж, туршлага судлав. - Дүүргийн Онцгой байдлын хэлтсээр байгууллагын Хадгаламжийн сангийн өрөөний галын аюулгүй байдлыг шалгуулж, дүгнэлт гаргуулсан. - 2019.09.07-ны өдөр Багануур дүүргээс Улсын үзлэг шалгалтын бэлтгэл ажлыг хангах 4 чиглэлээр зохион байгуулсан сургалтад байгууллагын улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах комиссын бүрэлдэхүүн хамрагдав. - 2016-2019 оны түүхчилсэн гэрэл зургийн архивыг бүрдүүлж, хадгаламжийн нэгж үүсгэсэн. 	100%
6	Багануур дүүргийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/147 дугаар захирамж	- Байгууллагын үйл ажиллагааг 2019.05.16-нд шалган зааварласан дүүргийн ажлын хэсгийн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу байгууллагын түүхчилсэн лавлахыг боловсруулж, он оны баяжилтыг хийсэн.	100%
7	"БҮТГ" ОНӨТҮГ-ын 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 6.5	Манай хороо – Миний гудамж аяны хүрээнд: <ul style="list-style-type: none"> - "Багануур тохижилт" ОНӨААТҮГ-ын албан хаагчдад компост бордоо хийх материал бэлтгэх талаар 2 удаа сургалт явуулж нийт 32 хүн, компост бордоо хийж үзүүлэх сургалтыг 4-р хорооны ТҮГ-ын үйлчилгээний цэгт зохион байгуулан 12 хүнийг тус тус хамруулав. 	100%

		- Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар эрдэст компост бордоо хийх туршилтыг 1 айлд зохион байгуулж, үзүүлэх сургалтаар хийсэн компост бордсоны явцыг шалгаж 10 хүнд зөвлөгөө өгсөн.	
8	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.4	НШУУИГ-т Паркийн 2020 оны хөрөнгө оруулалтын санал болон "Шинэ бүтээн байгуулалт" хөтөлбөрийн талаар уулзалт зохион байгуулж, зөвлөлдөв.	100%
9	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.5	Хүнд үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалт, төсөл хэрэгжүүлэх санал ирүүлсэн "Синкопа Монгол" ХХК, "Очир Ундраа" ХХК, Хүнс болон хөнгөн үйлдвэрийн салбарт төсөл хэрэгжүүлэх санал ирүүлсэн "Хемп Монгол" ХХК-тай уулзалт зохион байгуулж, санал солилцож Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, паркийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй танилцуулга хийв.	100%
10	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.3	Гурав дахь удаагийн "Монгол-Хятадын экспо"-ийн хүрээнд зохион байгуулагдах "Бүс нутгийн хамтын ажиллагаа, эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын чуулга уулзалт"-д Үндэсний хөгжлийн газраас тодорхойлсон ТОП 10 төсөлд багтсан Паркийн дэд бүтэц болон үйлдвэрүүдийн хөрөнгө оруулалтын танилцуулгыг Үндэсний Хөгжлийн Газраар уламжлуулан танилцуулсан.	100%
11	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1	ЖДҮДТ-тэй хамтын ажиллагааны төлөвлөгөөний дагуу хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэх модон тоглоомыг хийх талаар дүүргийн модон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчидтэй уулзалт хийж төсөл танилцуулах ажил хойшлогдсон.	0%
12	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.7	2019.09.03-ны өдөр Шинэ Анагаах Ухааны Их Сургуультай хамтын ажиллагааны төлөвлөгөөний дагуу хог хаягдлаар хийсэн компост бордоог хүргэж, эмийн ургамлын тариалалтад туршилт болгох арга хэмжээг эхлүүлсэн.	100%
Нэмэлт ажлууд			
13	2019.09.25-нд УУХҮЯ-ны геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт хэрэгжүүлж байгаа томоохон төсөл, хөтөлбөр бүтээн байгуулалтын талаар танилцуулах нээлттэй өдөрлөгт оролцохоор танилцуулга болон брошур бэлтгэж амжилттай оролцсон.		100%
14	Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явц, биелэлтийг гаргаж дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.		100%
15	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг гаргаж, хяналт шинжилгээ хийж даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн нийслэлийн ХШ,ҮХ-т хүргүүлсэн.		100%

16	Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар улирлын биелэлтийг гаргаж нийслэлийн НУУИГ-т хүргүүлэв.	100%
17	Нийслэлийн Шинжлэх Ухаан Үйлдвэрлэл, Инновацийн Газарт байгууллагын долоо хоногийн төлөвлөгөө, тайланг тогтмол хүргүүлэн ажиллаж байна.	100%
18	Байгууллагын албан хаагчдад egr.ulaanbaatar.mn системийн ашиглалтыг сайжруулах зорилгоор 2019.09.04-нд дотооддоо сургалт зохион байгуулав.	100%
19	Белорусс Улсын Их Сургуулийн инновацийн бүтээлийн үзэсгэлэнтэй танилцаж, туршлага судлав.	100%
20	Европ барилга үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах "Ий Пи Эм Констракшн" ХХК-д санамж бичгийн хугацааны тухай албан бичиг илгээв.	100%
21	Багануур дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр гаргаж дүүргийн Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэв.	100%
22	Багануур дүүргийн 40 жилийн ойн хүрээнд дүүргийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулах бүтээлч ажлын саналыг боловсруулж хүргүүлсэн.	100%

ХЯНАСАН:

"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК"
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН



ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Б.Мичид-Эрдэнэ* Б.МИЧИД-ЭРДЭНЭ